



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/40

Алтрага

Ариутгал, халдваргүйтгэл, сэг зэм
устгалын ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Мал эмнэлгийн Ерөнхий газрын 2024 оны А/34 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны А/122 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн ариун цэвэр, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн 05 дугаар сарын 20-ны дотор зохион явуулсугай.

2. Хорогдсон мал, амьтны сэг зэмийг шатаах, булах аргаар устгах, химийн аргаар халдваргүйжүүлэлт хийх, бохирлогдсон бэлчээр, малын хашаа хороо, өтөг бууц, уст цэг, өвөлжөө, хаваржааны орчныг цэвэрлүүлэх зэрэг шаардлагаар хийж гүйцэтгэх ажлуудыг хамтран зохион явуулахыг харьяа багийн Засаг дарга нар, Мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхлэх ААН-н захирал, дарга (Л.Дүүжий, Б.Тунгалагтуул), малчдын нөхөрлөлийн ахлагч нарт үүрэг болгосугай.

3. Сэг зэм устгалын ажлыг удирдан зохион байгуулан мэргэжил арга зүйн туслалцааг үзүүлж, дүн мэдээг хүргүүлж ажиллахыг тархварзүйч (Д.Энхтайван)-д, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажилд шаардагдах бензин шатахууны зардлыг Засаг даргын нөөцөөс тооцон олгохыг сумын Санхүүгийн албаны дарга (А.Дэлгэрмаа), ня-бо (Э.Ариунаа)-нарт зөвшөөрсүгэй.

4. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Ж.Даваажав)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010090